



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/03

Дэлгэрмөрөн

Төрийн байгууллагуудын олон нийтийг
хамруулан зохион байгуулах сургалт, семинар,
хурал, зөвлөгөөнийг түр хориглох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 59.1.23, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ний өдрийн А/09 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд коронавирусын халдварын тархалт өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан төрийн байгууллагуудын олон нийтийг хамруулан зохион байгуулах сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс 02 дугаар сарын 15-ний өдрийг хүртэлх хугацаанд түр хориглож, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсүгэй.

2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд зохих журмын дагуу хяналт тавьж, нийтийг хамарсан арга хэмжээг дээрх хугацаанд бүрэн зогсоохыг Тамгын газрын дарга (С.Нархүү), Цагдаагийн хэсэг (Ц.Пүрэвдорж), эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулалтын өндөр түвшинд хийж гүйцэтгэхийг Эрүүл мэндийн төв (М.Дорждагва) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА



С.СУМЪЯАБАЗАР

Zahiramj -2022 on

64 101179